

ҮНЭЛГЭЭНИЙ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

/АНД-ЭНЕРГИ ХК/

Компанийн засаглалын үнэлгээний асуулга					
Кодексийн хэрэгжилтийг “Хэрэгжүүл, эсвэл тайлбарла” гэсэн зарчмын дагуу тайлагнах ба кодексийн зүйл тус бүрээр биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, эсхүл авч байгаа, хэрэв төлөвлөж буй бол хугацаатайгаар нь тайлбар хэсэгт тусгана.					
НЭГ. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ					
ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна.					
№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Оноо	Хувь
1	<i>1.1. Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Анд-Энерги ХК-ийн 2018 оны 1-р сарын 21-ний өдөр батлагдсан “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-д ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан тусгасан байдаг. УБ үнэт цаасны биржийн компанийн засаглал хэрэгжүүлэх удирдамжийн 2.9.2.3-д зааснаар ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үйл ажиллагааны журмыг шинэчлэн баталсан. 2024 онд “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-ыг илүү сайжруулан батлахаар төлөвлөж байна.	2	100%
2	<i>1.2. Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримттай байна.</i>	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн, сайжруулалт хийхээр төлөвлөж байна.	Нэр дэвшүүлэх хорооны дүрэмд заасан тус хорооны чиг үүрэгт ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулахад тавигдах шаардлагыг тодорхойлох, холбогдох бодлогын баримт бичгийг боловсруулахыг тусгасан байдаг. Тус хорооноос ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг баталсан бөгөөд хараат бус гишүүдийг сонгон шалгаруулахдаа энэхүү шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээг хийдэг ба хорооны хурал дээр хэлэлцэж, нэр дэвшүүлдэг. Цаашид ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бичгийг шинээр боловсруулахаас гадна ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчид тавигдах шалгуур үзүүлэлтийг шинэчлэн сайжруулалт хийхээр төлөвлөж байгаа.	1	50%
3	<i>1.3. ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, цахим хуудсандаа байршуулна.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	2022 оноос эхлэн компанийн жилийн үйл ажиллагааны тайланд ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хуралд оролцсон ирц, хувьцааны эзэмшлийн холбогдох мэдээллийг дэлгэрэнгүй тусган тайлагнаж, компанийн цахим хуудсанд уг тайланг байршуулдаг.	2	100%

4	<i>1.4. Компани нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримттай байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэрт байдал зэргийг тусгана.</i>	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн, сайжруулалт хийхээр төлөвлөж байна.	“ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-д ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүтэц бүрэлдэхүүний тухай тусгасан байдаг. Мөн ТУЗ-ийн дэргэдэх хороод тус бүрийн дүрэмд бүрэлдэхүүний талаар тусгахаас гадна хорооны чиг үүрэг, гишүүдийн эрх үүрэг зэргийг тусгасан байдаг. ТУЗ болон бүх хороод тухайн жилд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг жилийн үйл ажиллагааны тайланд тайлагнахаас гадна Хувьцаа эзэмшигчдийн хурал дээр танилцуулдаг. 2024 онд “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-ыг шинэчлэхдээ ТУЗ-ийн гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэрт байдал зэргийг тусгахаар төлөвлөж байна.	1	50%
5	<i>1.5. ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, тэдгээрийг шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.</i>	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн, сайжруулалт хийхээр төлөвлөж байна.	ТУЗ-ийн гишүүдийг анх томилогдоход компанийн үйл ажиллагаа болон ТУЗ-ийн үйл ажиллагаатай холбоотой чиглүүлэх танилцуулгыг хийдэг. 2024 онд ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүд шинээр сонгогдох ба анх томилогдоход чиглүүлэх сургалтад хамруулахаар төлөвлөсөн. Тогтмол сургалтад хамруулдаггүй.	1	50%
6	<i>1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг ТУЗ-ийн даргын санал болгосноор Гишүүдийн олонхын саналаар томилдог бөгөөд ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээдэг.	2	100%
ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ					
ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг харнуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ.					
7	<i>2.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.</i>	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн, сайжруулалт хийхээр төлөвлөж байна.	ТУЗ нь нийт 9 гишүүнтэй бөгөөд гурван гишүүн нь хараат бус гишүүн байдаг. 2024 онд ТУЗ-ийн гишүүд шинээр сонгогдох ба гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорьж ажиллана. Хараат бус гишүүдийг олон нийтэд нээлттэй зар байршуулан анкетыг нь хүлээн авч нэр дэвшүүлэх хороо ирсэн материалаас хараат бус гишүүнт тавигдаж буй шаардлага хангаж байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгч ХЭХ-аар ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгодог.	1	50%
8	<i>2.2. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны үйл ажиллагааны журам 2023.02.15-нд шинэчлэгдэн батлагдсан. Тус хорооны даргаар ТУЗ-ийн дарга бус, хараат бус гишүүн томилогдон ажилладаг. Аудитын хороо хуралдах үед хурлын хэлэлцэх асуудлын дагуу хорооны хүсэлтээр холбогдох удирдлагууд хуралд оролцдог.	2	100%

9	2.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн, сайжруулалт хийхээр төлөвлөж байна.	ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны үйл ажиллагааны журам 2023.02.15-нд шинэчлэгдэн батлагдсан. Тус хорооны даргаар ТУЗ-ийн дарга бус хараат бус гишүүн томилогдон ажилладаг. Цалин урамшууллын хороо хуралдах үед хурлын хэлэлцэх асуудлын дагуу хорооны хүсэлтээр холбогдох удирдлагууд хуралд оролцдог. 2024 онд цалин урамшууллын бодлогын баримт бичгийг боловсруулан батлуулахаар төлөвлөж байна.	1	50%
10	2.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн, сайжруулалт хийхээр төлөвлөж байна.	ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны журам 2023.02.15-нд шинэчлэгдэн батлагдсан. Тус хорооны даргаар ТУЗ-ийн дарга бус хараат бус гишүүн томилогдон ажилладаг. Нэр дэвшүүлэх хороо хуралдах үед хурлын хэлэлцэх асуудлын дагуу хорооны хүсэлтээр холбогдох удирдлагууд хуралд оролцдог. 2024 онд залгамж халааны бодлогын баримт бичгийг шинэчлэн батлахаар төлөвлөж байна.	1	50%
11	2.5. ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршилага бүхий бүрэлдэхүүнтэй байна.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь: 1. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо 2. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо 3. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо гэсэн 3 хороотойгоор үйл ажиллагаа явуулж байна. 2024 онд ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг сайжруулан шинэчлэн батлахаар төлөвлөж байна. ТУЗ-ийн гишүүдийн хувьд хороодын чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршилагатай болно.	2	100%
ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ					
12	3.1. ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг 2024.02.19-нд ТУЗ-ийн хурлаар баглуулсан. Уг журмын хэрэгжилтэд ТУЗ хяналт тавьж ажиллана.	2	100%
13	3.2. ТУЗ нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн цахим хуудсанд хувьцаа эзэмшигч, олон нийтэд зориулан компанийн санхүү, үйл ажиллагаа болон засаглалтай холбоотой мэдээ мэдээллүүд байршуулдаг. Цаашид компанийн одоо ашиглаж буй цахим хуудсыг шинэчлэн сайжруулахаар төлөвлөсөн.	2	100%

14	3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрэн эсэхийг үнэлсэн мэдээлэл	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн, сайжруулалт хийхээр төлөвлөж байна.	Си Пи Ти Эй Аудит ХХК-ийн 2024 оны 2 сарын 27-ны өдрийн 23/02 тоот хараат бус аудиторын тайланд дүгнэлтэд санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой бодитой байна гэж дүгнэсэн.	1	50%
15	4.1. ТУЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, түүнийг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Бүрэн хэрэгжүүлсэн	Аудитын хорооны үйл ажиллагааны журмын 5.3-т хөндлөнгийн аудитортой харилцах, хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх боломжоор хангах, хяналт тавих тухай тусгасан байдаг.	2	100%
16	4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн, сайжруулалт хийхээр төлөвлөж байна.	Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцдоггүй ба аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд аудитын хорооноос томилогдсон гишүүн мэдээлэл өгдөг. Цаашид ХЭХ-ыг хуралд хөндлөнгийн аудитыг оролцуулах арга хэмжээг авч ажиллана.	1	50%
17	4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар олон нийтэд тухай бүр мэдээлнэ.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн, сайжруулалт хийхээр төлөвлөж байна.	Компанид дотоод аудитын тогтолцоо байхгүй бөгөөд үйл цаашид дотоод аудитыг бий болгож ажиллана. Цаашид компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар олон нийтэд тухай бүр нь мэдээлэх болно.	1	50%
ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА					
ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина.					
18	5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.	Хэрэгжилт байхгүй, сайжруулалт хийхээр төлөвлөж байна.	Компанид эрсдэлийн удирдлагын заавар, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүнг гаргаагүй байгаа бөгөөд цаашид эрсдэлийн удирдлагын журам боловсруулан төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавьж ажиллана.	0	0%
19	5.2. ТУЗ нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны	Хэрэгжилт байхгүй, сайжруулалт хийхээр төлөвлөж байна.	Төлөөлөн удирдах зөвлөл нь одоогоор эрсдэлийн удирдлага хариуцсан хороо байхгүй ба энэ жил шинээр сонгогдсон ТУЗ-ийн гишүүд уг хороог байгуулж эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц,	0	0%

	<i>тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана</i>		хуралдсан асуудал, давтамжийн талаар тайлагнах асуудлыг хэрэгжүүлж ажиллана.		
20	<i>5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.</i>	Хэрэгжилт байхгүй, сайжруулалт хийхээр төлөвлөж байна.	Үйл ажиллагааны тайланд нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажлын талаар дурдсан. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлаагүй. Цаашид тайлагнах болно.	0	0%
21	<i>5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.</i>	Хэрэгжилт байхгүй, сайжруулалт хийхээр төлөвлөж байна.	Компанид комплайнсын хяналтын заавар одоогоор байхгүй ба комплайнсын хяналтын заавар төслийн хэмжээнд боловсруулагдаж байна. Цаашид комплайнсын хяналтын зааврыг баталж, хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавьж ажиллах болно.	0	0%
ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ					
Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна.					
22	<i>6.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.</i>	Сайжруулалт хийхээр төлөвлөж байна.	Анд-Энерги ХК-ийн дүрмийн 11.9.3 дахь заалтыг үндэслэн төлөөлөн удирдах зөвлөлийн цалин урамшууллыг олгодог. ХЭХ-аар цаашид хэлэлцүүлэх болно.	2	100%
23	<i>6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримтад тусгана.</i>	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн, сайжруулалт хийгдэхээр төлөвлөж байна.	ТУЗ-ийн гишүүдийн хурлын идэвх, ирцэд үндэслэн цалинг олгодог. Гүйцэтгэх захирал жил бүрийн бизнес төлөвлөгөөнд компанийн бүтэц, орон тоо болон цалингийн хэмжээг ТУЗ-ийн хурлаар батлуулдаг. Ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг шинэчлэхээр төлөвлөж байна. Одоогоор цалин, урамшууллын бодлогын баримт бичиг байхгүй болно.	1	50%
24	<i>6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн, сайжруулалт хийгдэхээр төлөвлөж байна.	Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал урамшууллын мэдээллийг тусгасан. Шагнал болон урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг цаашид шинэчлэн боловсруулна.	2	100%
ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ					
Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ					
25	<i>7.1. Компани нь ТУЗ-өөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт</i>	Хэрэгжилт байхгүй,	Компани нь төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичиг төслийн түвшинд явж байна.	0	0%

ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ

Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана

32	<p><i>9.1. Компани оролцогч талуудад өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа тухай бүр хүргэнэ.</i></p>	<p align="center">Бүрэн хэрэгжүүлсэн</p>	<p>Компани нь мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмын хэрэгжилтийг ханган тухай бүр мэдээлэх мэдээллүүдийг Улаанбаатар үнэт цаасны бирж болон компанийн цахим хуудсаар дамжуулан хугацаанд нь мэдээлдэг.</p> <p>Бид компанийн цахим хуудасны бүтэц, агуулгаа шинэчлэн цаашид оролцогч талуудад илүү ойлгомжтой байдлаар компанийн санхүү болон үйл ажиллагаатай холбоотой тайлан, цаг үеийн мэдээ мэдээлэл, бодлого журмуудаа нээлттэйгээр мэдээлэх болно.</p>	<p align="center">2</p>	<p align="center">100%</p>
33	<p><i>9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба тэдэнтэй харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.</i></p>	<p align="center">Хэсэгчлэн хэрэгжүүлсэн, сайжруулалт хийгдэхээр төлөвлөж байна</p>	<p>Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр одоогоор байхгүй ба ба тэдэнтэй харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлэн ажиллаж байна.</p>	<p align="center">1</p>	<p align="center">50%</p>
34	<p><i>9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.</i></p>	<p align="center">Бүрэн хэрэгжүүлсэн</p>	<p>Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлж ажилладаг.</p> <p>“Хувьцаа эзэмшигчдийн хурлын журам”-ыг 2024.02.19-нд шинэчлэн баталсан бөгөөд хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулах агуулгыг нэмсэн.</p> <p>Энэхүү журмаар хувьцаа эзэмшигчдийн зүгээс хурлын хэлэлцэх асуудалд санал оруулах, хуралд оролцох, санал өгөх зэрэг эрхээ хэрэгжүүлэх, хувьцаа эзэмшигч нарт хурлын зарыг хүргэх, ХЭХ-ыг зохион байгуулахтай холбоотой бүхий л харилцааг зохицуулсан байдаг ба хэрэгжилтийг нь ханган ажилладаг.</p>	<p align="center">2</p>	<p align="center">100%</p>
35	<p><i>9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтцийн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.</i></p>	<p align="center">Бүрэн хэрэгжүүлсэн</p>	<p>Компани нь хувьцаа эзэмшигчдийнхээ эрхийг хүндэтгэн, Компанийн тухай хуульд заасан эрхээ хэрэгжүүлэх боломжоор нь хангахад анхаарч, аливаа шийдвэрийг гаргахдаа засаглалын сайн зарчмыг баримтлан ажилладаг.</p>	<p align="center">2</p>	<p align="center">100%</p>
36	<p><i>9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.</i></p>	<p align="center">Бүрэн хэрэгжүүлсэн, сайжруулалт хийгдэхээр төлөвлөж байна.</p>	<p>Биржтэй байгуулсан бүртгэлийн гэрээ, гэрээний нөхцөлийн дагуу мэдэгдэж байгаа.</p> <p>Сонирхлын зөрчилтэй гэрээ хэлэлцэл хийх журам одоогоор байхгүй бөгөөд цаашид журам боловсруулж хэрэгжилтийг олон нийтэд мэдээлэх болно.</p>	<p align="center">2</p>	<p align="center">100%</p>